Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалалд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа

П.Золжаргал[1], С.Мөнхбат[2], П.Мандахнаран[2]

[1]АШУҮИС, Эм зүйн сургуулийн магистрант
[2]АШУҮИС, Эм зүйн сургууль
Цахим хаяг: zoloopurew@gmail.com, Утас: 99981177

Түлхүүр үг:
Эм зүйч
Эм найруулагч
Хронометражийн арга

Товч утга: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг салбар бол эм хангамжийн салбар юм. Олон улсад хийгдсэн судалгаанаас харахад эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин гүйцэтгэж буй ажлын ачаалалтай харьцуулахад бага, ажлын ачаалал их байгаагаас өөр салбарт шилжих хандлага эрс нэмэгдэж байгааг дурьджээ.[1] Эрүүл мэндийн ажилчдын, түүний дотор нийтийн үйчилгээтэй эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалал, хөдөлмөрийн нормчлолыг зөв тогтоох нь эм зүйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд чухал ач холбогдолтой юм.[3-6] Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалалд боловсролын зэрэг, ажилласан жил, эмийн сангийн зэрэглэлийн хувьд ялгаатай эсэхийг тодорхойлох зорилгоор УБ хотын 9 дүүрэгт байрлах нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж байгаа 134 жор баригчийг хронометражийн аргаар судлаж, ANOVA шинжилгээний аргыг ашиглан статистик боловсруулалтыг хийсэн. Судалгаанд оролцсон жор баригчдын 9%(12) нь дипломын боловсролтой, 76.9%(103) нь бакалаврын боловсролтой, 12.7%(17) нь магистрын зэрэгтэй, 1,5%(2) нь докторын зэрэгтэй байсан. Ажлын туршлага нь 1-2 жил 24.6%(33), 3-5 жил 40.3%(54), 6-10 жил 17.2%(23), 10-с дээш жил 17.9%(24)-ийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан жор баригчдын 26.1%(35) нь 1-р зэрэглэлийн эмийн санд, 73.9%(99) нь 2-р зэрэглэлийн эмийн санд ажиллаж байна. Судалгааны дүнгээс харахад эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалал нь боловсролын зэрэг, ажилласан жил, эмийн сангийн зэрэглэл нөлөөлөхгүй байна.

Үндэслэл: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг салбар бол эм хангамжийн салбар юм. Олон улсад нийтлэгдэснээр эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин гүйцэтгэж буй ажлын ачаалалтай харьцуулахад бага, ажлын ачаалал их байгаагаас өөр салбарт шилжих хандлага эрс нэмэгдэж байгааг дурьджээ.[1]

Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа өөрчлөлт шинэчлэлийн томоохон хэсэг нь тус мэргэжилтний ажлын ачааллыг зөв хуваарлах, зөв үнэлэх, байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг байна.[1] Одоогоор мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримтанд эмнэлгийн мэргэжилтэнд ур чадварын зэргийн нэмэгдэл, хүнд хортой нөхцөл, зэрэгт нэмэгдэл цалин олгогддог хэдий ч ажлын гүйцэтгэлийн үр дүн, ажилласан бодит хугацаа, мэдлэг туршлага, ажлын ачаалал зэргийг бүрэн үнэлэхгүй байна.[1] Эмнэлгийн ажилтны ачаалал их байх нь ажлын гүйцэтгэл болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд нөлөөлдөг байна.[2]

Эрүүл мэндийн ажилчдын, түүний дотор нийтийн үйчилгээтэй эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалал, хөдөлмөрийн нормчлолыг зөв тогтоох нь эм зүйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд чухал ач холбогдолтой юм.[3-6] Олон улсад

хронометражийн аргаар жор баригчийн ажлын ачааллыг боловсронгуй болгох судалгааны ажлууд цөөнгүй байгаа юм.[6,7] Иймд нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалалыг хронометражийн аргаар судлах үндэслэл боллоо.


Зорилго, зорилт: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалалд боловсролын зэрэг, ажилласан жил, эмийн сангийн зэрэглэлийн хувьд ялгаатай эсэхийг тодорхойлох

1. Эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалал нь боловсролын зэргээс шалтгаалан ялгаатай эсэх
2. Жор баригчийн ажлын ачаалал нь ажилласан жилтэй хамааралтай эсэх
3. Эмийн сангийн зэрэглэл нь жор баригчийн ажлын ачаалалд нөлөөлж буй эсэх

Арга, аргачлал: Судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж байгаа 1860 эм зүйч, 840 эм найруулагчаас эмийн санд суурилсан зорилтот түүврийн аргыг ашиглан 134 жор баригчийг хамруулсан. Хронометражийн ажиглалтын аргаар “Ажлын өдрийн зураглал буюу хроно хуудас”-ыг бүртгэж, жор баригчдийг 2020 оны 12-р сарын 15-аас 2021 оны 4 сарын 1-нийг хүртэлх хугацаанд судлав. Боловсруулалтыг хийхдээ Microsoft Office Excel программд мэдээллийн сан үүсгэж, статистикийн STATA программ хангамжийг ашиглан, ANOVA шинжилгээний аргыг ашиглан бодит тоо, эзлэх хувь, дундаж, стандарт хазайлт, хамгийн их, хамгийн бага утгыг тодорхойлсон. Статистик ач холбогдлыг p-утга 0.05-аас бага байх тохиолдолд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдлаа гэж үнэлсэн бөгөөд их байх үед ач холбогдол бүхий ялгаагүй гэж үнэлсэн.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж байгаа жор баригчдын 14.18%(n=19) нь 18-25 настай, 59.7%(n=80) нь 26-35 настай, 16.4% (n=22) нь 36-45 настай, 9.7%(n=13) нь 45-с дээш насны жор баригчид эзэлж байсан. Эмийн сангийн байршлаар нь авч үзэхэд Баянзүрх дүүрэгт 26.1%(35), Сүхбаатар дүүрэгт 12.7%(17), Баянгол дүүрэгт 14.2%(19), Хан-Уул дүүрэгт 19.4%(26), Сонгинохайрхан дүүрэгт 14.2%(19), Чингэлтэй дүүрэгт 7.5%(10), Багахангай дүүрэгт 1.5%(2), Налайх дүүрэгт 4.5%(6) ажиллаж байна. Боловсролын түвшингээр нь авч үзэхэд дипломын боловсролтой жор баригч 9%(12), бакалаврын боловсролтой 76.9%(103), магистрын зэрэгтэй 12.7%(17), докторын зэрэгтэй 1.5%(2) эзэлж байна.

Цалингийн хэмжээ нь 420,000₮-600,000₮ 6.7%(9), 601,000₮-800,000₮ 35.8%(48), 801,000₮-1,000,000₮ 34.3%(46), 1 саяас дээш 23.1%(31) байна (Зураг 1).



Зураг 1. Сарын дундаж цалингийн хэмжээг боловсролын зэргээр харьцуулсан байдал

Өдөрт дунджаар үйлчилдэг хүний тоо нь 40-60 хүнд 25.4%(34), 60-80 хүнд 28.4%(38), 80-100 хүнд 26.1%(35), 100-с дээш хүнд 20.1%(27) байна.

Ажлын цаг нь 12-13 цаг – 53%(71), ажлын 8 цагаар – 32.8%(44), 24/48 цагаар – 14.2%(19) байна. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчдын нэг өдрийн ажлын цагийг боловсролын зэрэгтэй харьцуулсаныг хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчдын нэг өдрийн ажлын цагийг боловсролын зэрэгтэй харьцуулсан байдал

Ажлын цаг зарцуулалт	Боловсролын зэрэг	Дундаж	Стандарт хазайлт	ANOVA	
				F-stat	*p-утга*
Үндсэн ажил	Доктор	8	0	2.15	0.0974
	Бакалавр	7.15	2.395		
	Диплом	6.49	2.194		
	Магистр	8.46	2.004		
Бэлтгэл ажил	Доктор	5	0	2.38	0.0727
	Бакалавр	5.18	1.7		
	Диплом	4.55	1.254		
	Магистр	6.33	3.307		
Амралт чөлөөт цаг	Доктор	0.92	0	2.19	0.0924
	Бакалавр	0.67	0.425		
	Диплом	0.75	0.318		
	Магистр	0.93	0.355		

Хүснэгт 1-с харахад үндсэн ажил ($p<0.09$), бэлтгэл ажил ($p<0.07$), амралт чөлөөт цаг ($p<0.09$) зарцуулж байгаа хугацаа нь боловсролын зэргээр статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй.

Ажлын туршлага нь 1-2 жил 24.6% (33), 3-5 жил 40.3% (54), 6-10 жил 17.2% (23), 10-с дээш жил 17.9% (24) байна.

Хүснэгт 2. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчдын нэг өдрийн ажлын цагийг ажилласан жилтэй харьцуулсан байдал

Ажлын цаг зарцуулалт	Ажилласан жил	Дундаж	Стандарт хазайлт	ANOVA	
				F-stat	*p-утга*
Үндсэн ажил	1-2 жил	6.85	2.633	1.42	0.2399
	3-5 жил	7.04	2.301		
	6-10 жил	7.83	2.649		
	10-с дээш жил	7.83	1.566		
Бэлтгэл ажил	1-2 жил	5.08	1.557	0.33	0.8022
	3-5 жил	5.29	1.795		
	6-10 жил	5.61	2.655		
	10-с дээш жил	5.22	2.244		
Амралт чөлөөт цаг	1-2 жил	0.6	0.388	2.18	0.094
	3-5 жил	0.71	0.435		
	6-10 жил	0.88	0.412		
	10-с дээш жил	0.69	0.365		

Хүснэгт 2-оос харахад үндсэн ажил (p<0.23), бэлтгэл ажил (p<0.8), амралт чөлөөт цагт (p<0.09) зарцуулж байгаа хугацаа нь ажилласан жилээр авч үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй. Судалгаанд хамрагдсан жор баригчдын 26.1% (35) нь 1-р зэрэглэлийн эмийн санд, 73.9%(99) нь 2-р зэрэглэлийн эмийн санд ажиллаж байна. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчдын нэг өдөрт зарцуулах ажлын цагийг эмийн сангийн зэрэглэлтэй харьцуулсныг Хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчдын нэг өдөрт зарцуулах ажлын цагийг эмийн сангийн зэрэглэлтэй харьцуулсан байдал

Ажлын цаг зарцуулалт	Эмийн сангийн зэрэглэл	Дундаж	Стандарт хазайлт	t	p-утга
Үндсэн ажил	1-р зэрэглэл	7.45	2.391	0.342	0.7127
	2-р зэрэглэл	7.24	2.365		
Бэлтгэл ажил	1-р зэрэглэл	5.11	1.683	-0.387	0.8458
	2-р зэрэглэл	2.31	2.036		
Амралт чөлөөт цаг	1-р зэрэглэл	0.83	0.4	1.347	0.7356
	2-р зэрэглэл	0.69	0.41		
Нийт цаг	1-р зэрэглэл	13.4	3.504	0.159	0.8618
	2-р зэрэглэл	13.25	3.797		

Хүснэгт 3-с харахад үндсэн ажил (p<0.71), бэлтгэл ажил (p<0.8), амралт чөлөөт цаг (p<0.73), нийт (p<0.86) зарцуулж байгаа хугацаа нь эмийн сангийн зэрэглэлээр авч үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй. Жор баригчдын бэлтгэл ажилдаа зарцуулж буй дундаж цаг нь 1-р зэрэглэлийн эмийн санд -5.11, 2-р зэрэглэлийн эмийн санд 2.3 хоорондоо ялгаатай байна.

Хэлцэмж: Эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын тоо дэлхийн жишигт нийцсэн хэдий ч ажлын ачаалал ихтэй байгаа нь ажлын зохион байгуулалт хангалтгүй байдагтай холбоотой юм.[3] Бидний судалгаагаар нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн өдөрт эм зүйн тусламж үзүүлдэг хүний тоо нь 40-60 хүнд 25.4%(34), 60-80 хүнд 28.4%(38), 80-100 хүнд 26.1%(35), 100-с дээш хүнд 20.1%(27) байна.

Өндөр чанартай тусламж үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн салбарт ажиллагсадын ажлын хэт ачаалал, хамтын ажиллагаа бага байх, ажлын цаг хангалтгүй байх зэрэг нөлөөлдөг байна.4-6 Бидний судалгаагаар жор баригчийн үндсэн ажил, амралт чөлөөт цагт зарцуулж байгаа хугацаа нь эмийн сангийн зэрэглэлээр авч үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй боловч бэлтгэл ажилдаа зарцуулж буй дундаж цаг нь 1-р зэрэглэлийн эмийн сан, 2-р зэрэглэлийн эмийн санд хоорондоо ялгаатай байсан.

АНУ-д хийгдсэн нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эм зүйчдийн ажлын ачааллын тандалт судалгаагаар ажлын ачаалал хэт өндөр буюу 14%-р өссөн ба 61% нь ажлын ачаалал хэт их байгаа гэсэн хариут өгсөн бөгөөд үр дүнд ажлын ачаалал хэт их байх нь ажлын гүйцэтгэл болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд нөлөөлж байна гэж үзжээ.[7]

Дүгнэлт:

1. Эмийн сангийн жор баригчийн ажлын ачаалал нь боловсролын зэргээс шалтгаалан статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй (p<0.09).
2. Жор баригчийн ажлын ачаалал нь ажилласан жилээс хамааралгүй байна.
3. Жор баригчийн ажлын ачаалалд эмийн сангийн зэрэглэл нөлөөлөхгүй байна.

Талархал: Энэхүү судалгаанд оролцсон жор баригч нартаа талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *С.Мягмарчулуун, Ч.Цолмон, Л.Оюунтогос. Монгол улсад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч нарын*

ажлын ачаалал. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ, 2015, х.16-21
2. М.Номингэрэл, Д.Хишигтогтох, О.Болорсайхан. Сувилагч мэргэжилтний ажлын ачаалал, хэтийн төлөвийг тодорхойлох нь. Сувилахуйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдвэт бүтээл. УБ, 2017,х.9
3. Dragana Nikic, Mirjana Arandjelovic, Maja Nikolic and Aleksandra Stankovic Job satisfaction in health care workers. Acta Medica Medianae 2008; 47 (4): 9-12.
4. Bogue, R. J., Guarneri, J. G., Reed, M., Bradley, K., & Hughes, J. (2006). Secrets of physician satisfaction: Study identifies pressure points and reveals life practices of highly satisfied doctors. Physician Executive, 32, 30-39.
5. Katerndahl, D., Parchman, M., & Wood, R. (2009). Perceived complexity of care, perceived autonomy, and career satisfaction among primary care physicians. Journal of the American Board of Family Medicine, 22, 24-33.
6. Linzer,M.,Manwell,L.B.,Williams,E.S.,Bobula,J.A.,Brown,R.L.,-Varkey,A.B., ... Schwartz, M. D. (2009). Working conditions in primary care: Physician reactions and care quality. Annals of Internal Medicine, 151, 28-36.
7. Michelle A. Chui, Community Pharmacists' Subjective Workload and Perceived Task Performance: a Human Factors Approach, https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC3624986/. Accessed December 20, 2020.
8. Эм зүйн салбарын үзүүлэлт 2018, ЭМХТ, АХБ, 2018 он, УБ, х.15-16
4. Эм зүйн салбарын үзүүлэлт 2019, ЭМХТ, АХБ, 2019 он, УБ, х.21-22
5. Б.Отгонбат, Д.Энхжаргал, Ч.Ерөөлт. УБ хотын лавлагаа шатлалын эмнэлэгүүдийн амбулаториор үйлчлүүлэгсдэд жороор олгосон эмийн зохистой хэрэглээний судалгаа, Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдвэрт бүтээлийн хураангуй. УБ, 2017, х.15-16
6. Б.Шинэцэцэг, С.Мөнхбат, П.Мандахнаран. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эмийн мэргэжилтнүүдийн сэтгэл ханамж, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх хүчин зүйл. Эм зүй сэтгүүл, 2020, № 2, хуудас 192-198.
7. https://www.pharmacytimes.com/news/pharmacists-are-happy-with-their-salaries-less-so-with-their-jobs-survey-shows-part-1 Accessed December 20, 2020.
8. Эмийн сангийн стандарт MNS: 5260: 2015
9. Их эмч, эм зүйчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай, ЭМС-ын 2012 оны 05 сарын 18-ны өдрийн 182 тоот тушаал
10. Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал тооцох, хөдөлмөрийн норм, норматив тогтоох тухай, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал, 2010 оны 05 сарын 30-ны өдөр, Дугаар А/185, А/252

The survey of the factors influencing to workload of pharmacists in a community pharmacy

Zoljargal.P[1], Munkhbat.S[1], Mandakhnaran.P[1]*

[1]MNUMS, School of Pharmaceutical
Email:zoloopurew@gmail.com, Tel: 99981177

Background: One of the major sectors of health care is the drug supply sector. An international study found that wages of workers in the health sector were lower than their workload and that there was a increase in the shift to other sectors due to the workload.Properly setting the workload standards for health sector workers, including pharmacist works in a public service pharmacies is important for the quality of pharmaceutical care.
Purpose: The purpose is to determine whether the workload of pharmacist in public service pharmacy is affected by the pharmacist's education degree, experience and pharmacy rating.
Materials and Methods: The research involved 134 pharmacists working in community pharmacies in 9 District of Ulaanbaatar. The workload of the pharmacist was studied by ANOVA analysis method.
Results: There are total number of 134 pharmacist has participated in the research. The educational level of pharmacist are 9%(12) associates with diploma, 76.9%(103) with bachelor's degree, 12.7%(17) with master's degree and 1.5%(2) are with doctoral degree. There are work experience of the participants are 24.6% (33) 1-2 years of experience, 40.3%(54) 3-5 years of experience, 17.2%(23) 6-10 years of experience and rest of 17.9%(24) has experience of 10 plus years. There are 26.1%(35) pharmacists working in 1st degree pharmacy, 73.9%(99) pharmacists working in 2nd degree pharmacy.
Conclusions: The results of the survey show that the workload of pharmacist is not affected by the pharmacist degree of education, experience and pharmacy degree.

Key words: Pharmacist, pharmaceutical technician, timing method